


ДОТООДЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ, индекс

Энэ сард зах зээлийн үнэлгээ 1.26 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 180.2 тэрбум төг буюу 12.5 хувиар буурлаа. MSE all индекс 872.04 бөгөөд өмнөх сараас 4.4 хувиар буурсан байна.



Компаниудын зах зээлийн үнэлгээнд эзлэх хувь

Энэ сард нийт 208 компаниас топ 5-д АПУ 289.4 тэрбум төгрөг, Тавантолгой 155.4 тэрбум төгрөг, Говь 66.2 тэрбум төгрөг, УБ БҮК 52.1 тэрбум төгрөг, Багануур 51.8 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй орж байна.


Компаниудын ЗЗҮ-нд эзлэх хувь



Хувьцааны арилжааны үнийн дүн

Энэ сард хувьцааны арилжааны үнийн дүн 21.11 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 6.9 тэрбум төгрөг буюу 25 хувиар буурсан байна. МХБ-ийн нийт арилжаанд хувьцаа 38 хувь, ЗГҮЦ-ны арилжаа 62 хувь эзэлж байна.


Арилжааны үнийн дүн /тэрбум.төг/



Нийт хийгдсэн хэлцлийн тоо

Энэ сард нийт 1098 хэлцэл хийгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэлцлийн тоо 347 буюу 46.2 хувиар өссөн байна.


Нийт хийгдсэн хэлцлийн тоо



Үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо

Энэ сард үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо 71 байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 компаниар буурсан байна.


Үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо



Нийт арилжаанд идэвхитэй арилжигдсан үнэт цаасны эзлэх хувь

Энэ сард нийт 72 компанийн хувьцаа арилжаалагдсанаас эхний ТОП 5-д Таван толгой 1.14 тэрбум төгрөг, Говь 90.8 сая төгрөг, АПУ 81.0 сая төгрөг, БиДиСек 54.3 сая төгрөг, Атар-Өргөө 42.38 сая төгрөгийн хувьцаа арилжаалсан байна.


Идэвхитэй арилжигдсан үнэт цаасны компани



Засгийн газрын үнэт цаасны арилжаа

Энэ сард ЗГҮЦ-ны арилжаа 470.8 тэрбум төгрөгийн арилжаалагдсан бөгөөд үүнээс МХБ 7.4 хувийг, Монголбанк 92.6 хувийг нь арилжаалсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ЗГҮЦ-ны нийт арилжааны үнийн дүн 194.9 тэрбум төгрөг буюу 70.6 хувиар өссөн байна.


Засгийн газрын үнэт цаасны арилжаа /тэрбум.төг/



Үнэт цаасны компанийн ЗГҮЦ-ны арилжаанд эзлэх хувь

Энэ сард нийт 12 үнэт цаасны компани ЗГҮЦ-ны арилжаанд оролцсоноос эхний ТОП 5-д Би Ди Сек 13.33 тэрбум төгрөг, Новел инвестмент 8.6 тэрбум төгрөг, Тэнгэр капитал 6.6 тэрбум төгрөг, Монсек 4.1 тэрбум төгрөг, Стандарт инвестмент 1.8 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

ЗГҮЦ-ны арилжаанд ҮЦК-ны эзлэх хувь



АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

Жолоочийн албан журмын даатгал

Энэ сард жолоочийн албан журмын даатгалын хураамжийн орлого 1.47 тэрбум төгрөг, нөхөн төлбөр 0.19 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 32 хувиар өсч, нөхөн төлбөр 76 хувь буурсан байна.


Жолоочийн албан журмын даатгал /тэрбум.төг/



Зах зээлд эзлэх хувь

Энэ сард албан журмын даатгалын хураамжийн орлогоор 5 топ компанид Монгол даатгал 203.9 сая төгрөг, Мандал даатгал 183.9 сая төгрөгийн, Миг даатгал 177.4 сая төгрөг, Бодь даатгал 171.6 сая төгрөг, Практикал даатгал 131.7 сая төгрөгийн орлоготой байна.

Даатгалын компанийн зах зээлд эзлэх хувь




Тайлбар: 2015.12.31 өдрийн мэдээлэл болно.

БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Арилжааны үнийн дүн


Энэ сард ХААБ-ын арилжааны үнийн дүн 12.7 тэрбум төгрөг байсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 214.1 төгрөг буюу 1.7 хувь өссөн байна.

Арилжааны үнийн дүн /тэрбум.төг/



Биелсэн хэлцлийн тоо

Энэ сард ХААБ дээр биелсэн хэлцлийн тоо 164 байсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэлцлийн тоо 28 буюу 21 хувь өссөн байна.



Зах зээлд эзлэх хувь

Энэ сард ХАА-н биржийн арилжаанд нийт 7 брокерын компани оролцсон ба Танан дээж трэйд 5.1 тэрбум төгрөг, МЭТҮ 4.9 тэрбум төгрөг, Алтан шагай импекс 1.3 тэрбум төгрөг, Цэц-Инвест 0.6 тэрбум төгрөг, Ханбүргэд хэнтий 0.33 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

ХАА-н брокерын компаниудын зах зээлд эзлэх хувь



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Зээлийн батлан даалт

Энэ сард зээлийн батлан даалт авах 1.77 тэрбум төгрөгийн 10 хүсэлт ирснээс 88.4 хувь буюу 1.56 тэрбум төгрөгийн 8 хүсэлтийг олгохоор шийдвэрлэсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хувь буурсан байна.

Тайлбар: Зөвхөн ЗБДС-аас олгохоор шийдвэрлэсэн батлан даалтын хэмжээ болно.




Эх сурвалж: СЗХ-ны зохицуулалтын байгууллагууд

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2015 оны эхний 3-н улиралд 11 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 286.4 тэрбум төг буюу 2.5 хувиар өслөө. Үүнд: ХАА салбар 12.8 хувь, аж үйлдвэр, үйлчилгээний салбар 6.2 хувиар тус тус өсөж удааширч байгаа нь аж үйлдвэр, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт бага байгаатай холбоотой. ДНБ, оны үнээр 2015 оны эхний 9 сард 16834.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 665.1 тэрбум төг буюу 4.1 хувиар өссөн.



Төсөв


Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5973.8 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 7136.9 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1163.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 295.2 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 4.7 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жилийн эцсийн байдалаар, тэрбум төг




Гадаад худалдаа

Нийт бараа эргэлт 2015 онд өмнөх оныхоос 2544.4 сая ам.доллар буюу 23.1 хувь, үүний дотор экспорт 1104.9 сая ам.доллар буюу 19.1 хувь, импорт 1439.5 сая ам.доллар буюу 27.5 хувиар буурчээ.



Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2015 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.2 хувиар буурахад орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Оны эхнээс 1.9 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 23.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

МӨНГӨНИЙ ТОЙМ


Мөнгөний нийлүүлэлт



Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 2.5 хувиар өссөн ч өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар буурч 10050.2 тэрбум төгрөгт болжээ.

Тус 5.5 хувиар буурсны 0.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, -0.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -0.4 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -0.9 нэгж хувийг төгрөгийн харилцах, -4.3 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлсэн байна.

Зээл, зээлийн хүү




Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээл өмнөх сарынхаас 1.6 хувь буюу 193.5 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 6.5 хувь буюу 806.8 тэрбум төгрөгөөр буурч 11.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Харин банкуудаас МИК ОССК-д шилжүүлсэн зээл-ийг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл 13.7 их наяд төгрөг байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 85.6 хувийг хэвийн зээл, 7.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 7.1 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.0 нэгж хувиар өссөн байна.

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2015 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өсч жилийн 13.0 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурч жилийн 19.13 хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурч жилийн 12.0 хувь болжээ.


Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2015 оны 12 дугаар сарын эцэст 1995.51 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 107.1 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 1995.8 төгрөг байв.



Орон сууцны үнийн индекс

Тухайн 12 сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 1.1 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 11.3 хувиар тус тус буурчээ. Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ энэ сард 2,050,000 төгрөг болж өмнөх сараас 0.1 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 4.6 хувиар тус тус буурсан байна. Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ энэ оны эхэнд 98 сая сард 84 сая төгрөг болж оны эхнээс 14.3 хувиар буурч байна.



Орон сууцны зээл



Тухайн сард нийт 843 зээлдэгчид 46.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3433.0 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 77105-д хүрчээ. Тайлант сард шинээр олгосон зээлийн 70.7 хувь буюу 33.1 тэрбум төгрөг нь ОСИСТБХ-ийн зээл, 29.3 хувь буюу 13.7 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна. Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 54.8 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.3 хувь нь 16-20 жил, 17.2 хувь нь 11-15 жил, 9.6 хувь нь 6-10 жил, 1.8 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.

Тайлбар: ОСИСТБХ -“Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”

Эх сурвалж: Монголбанк <http://www.mongolbank.mn/>, “Тэнхлэг зууч ХХК”

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


Эдийн засгийн өсөлт

Бодит ДНБ-ийн жилийн өсөлт тус графикт 2012 оноос хойш Хятад улс буурч байхад бусад нь өсөх хандлагатай байна. Хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн өсөлтөөс хөгжингүй орнуудын өсөлт илүү хурдтай байх хандлагатай байна.



Инфляц

Жилийн инфляц тус графикт 2012 оноос хойш дэлхийн хандлага буурч байхад Хятад, ОХУ-д өсөх хандлагатай байна. Хөгжиж байгаа орнуудын жилийн инфляцийн бууралтаас хөгжингүй орнуудын инфляц илүү хурдтай буурах хандлагатай байна.




Экспорт, импортын өсөлт

2015 онд дэлхийн цэвэр экспорт хасах гарах бол зүүн азийн цэвэр экспорт нэмэх гарах хандлагатай байна. Дэлхийн экспорт, импортын өсөлтөөс Зүүн азийн өсөлт илүү байх хандлагатай байна.




Металлын ханш

2015 оны 9 дүгээр сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 трой унц /31.1 гр / алт 9 хувь, цагаан алт 29 хувь, мөнгө 20 хувь үнэ буурсан байна. 2015 оны 9 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад 1 трой унц алт 0.6 хувь өсч, цагаан алт 2 хувь, мөнгө 1.3 хувь үнэ буурсан байна.



Түлшний ханш

2015 оны 9 дүгээр сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад сая тонн нүүрс Австралид 18 хувь, сая тонн байгалийн хий Америкт 32 хувь, Европт 27 хувь, Японд 41 хувь буурсан байна.



Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, НҮБ

Хаяг: Засгийн газрын IV байр, Бага тойруу-33, Улаанбаатар-15160, Утас: +976 51 265633, www.frc.mn